

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.05.20-05.24

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудал хүндэрч, АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд буурч хаагдлаа.

S&P 500 индексийн сагсанд багтаж буй эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш хамгийн мхээр унасан бол өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна.

"Microsoft" компани клауд үйлчилгээний серверүүдийнхээ нэгээс "Huawei"-ийн бүтээгдэхүүнийг буулгалаа. Тус компанийн "Azure Stack" бүтээгдэхүүний цахим хуудсыг харвал "Huawei"-ийн лого үндсэн цэс дээр байгаа ч санал болгож буй бүтээгдэхүүнүүдийн жагсаалтад "Huawei"-ийн бүтээгдэхүүнүүд багтаагүй байна. Энэ талаар "Microsoft" албан мэдэгдэл хийхээс татгалзжээ. Түүнчлэн тус компани "Huawei"-ийн "Windows" үйлдлийн систем ашиглах лицензийг цуцлах эсэх нь одоогоор тодорхойгүй байна.

Долоо хоногийн өмнө АНУ-ын Засгийн газар "Huawei"-д хориг тавьж, хар жагсаалтад оруулсан юм. Үүний дараа АНУ-ын компаниуд "Huawei"-ийн эсрэг ямар арга хэмжээ авах, энэ нь "Huawei" болон түнш байгууллагуудад хэрхэн нөлөөлөх нь олон улсад анхаарал татаж байна. Үүнээс өмнө "Intel", "Qualcomm", "Broadcom" зэрэг компаниуд тодорхойгүй хугацаанд "Huawei"-д нийлүүлэлтээ зогсоожээ.

Европ: АНУ, БНХАУ-ын хоорондын худалдааны маргаан хурцдаж Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд буурчээ.

Их Британийн Ерөнхий сайд хатагтай Тереза Мэй ирэх 6-р сарын 7-нд Их Британийн Консерватив намын даргын албан тушаалыг хүлээлгэн өгөхөөр болсноо зарлаад байна. Өөрөөр хэлбэл тэрбээр Их Британийн Ерөнхий сайдын албан тушаалаас буухаар болж байгаа юм. Ингэснээр Их Британийн фүнтийн ханш ам.долларын эсрэг бага зэрэг суларчээ.

Япон: АНУ-ын Ерөнхийлөгч автомашин болон автомашины эд ангийн импортод тарифын арга хэмжээ авахаар төлөвлөөд байгаа аж. Харин уг мэдэгдэлд "Toyota"-ийн Ерөнхийлөгч төдийгүй "Jama" худалдааны байгууллагын ТУЗ-ийн дарга Акио Тоёода нар сөрөг байр суурьтай байна.

БНХАУ: Юанийн ханш ам.долларын эсрэг 15 өдөр дараалан унасны эцэст эргэн сэргэлээ. БНХАУ-ын Төв банк юанийн албан ханшийг таамаглаж байснаас өндөр тогтоосон байна. 5-р сар гарснаас хойш "Худалдааны дайн" хурцдаж үүнтэй зэрэгцээд юань ам.долларын эсрэг 2.5 хувиар сулраад байгаа юм. Ингэснээр юань нөлөө бүхий валютууд дотроос хамгийн тааруу гүйцэтгэлтэй валютад тооцогдож байна. БНХАУ-ын бодлого боловсруулагчид юанийн ханшийг сулруулах хүсэлгүй байгааг албан ханшийг өндөр тогтоосноос харж болохоор байна гэж "Australia & New Zealand Banking Corp"-ийн шинжээч онцолж байна.

Эх сурвалж: Troweprice.com, BloombergTv.mn

Олон улсын индексүүд

| Индекс | Улс | Хаалт | Өөрчлөлт |
|-------------|------------|-----------|-----------|
| MSE TOP 20 | Монгол | 19,952.98 | -1.45% ▼ |
| Dow Jones | АНУ | 25,585.69 | -0.69% ▼ |
| S&P 500 | АНУ | 2,826.06 | -1.17% ▼ |
| Nasdaq | АНУ | 7,637.01 | -2.29% ▼ |
| S&P/TSX | Канад | 16,230.04 | -1.05% ▼ |
| FTSE 100 | Их Британи | 6,575.37 | -10.52% ▼ |
| S&P/ASX 200 | Австрали | 6,456.00 | 1.42% ▲ |
| Nikkei 225 | Япон | 21,117.22 | -0.63% ▼ |
| Hang Seng | Хонг Конг | 27,353.93 | -2.12% ▼ |

Бондын өгөөж

| Бонд | Валют | Купон | Үнэ |
|------------------------|-------|---------|--------|
| Mongol 2024 (Хуралдай) | USD | 8.750% | 110.48 |
| Mongol 2023 (Гэрэгэ) | USD | 5.625% | 99.14 |
| Mongol 2022 (Чингис) | USD | 5.125% | 98.68 |
| Mongol 2021 (Мазаалай) | USD | 10.875% | 110.17 |
| DBM' 23 (Самурай) | JPY | 1.520% | 104.10 |
| DBM' 2023 | USD | 7.250% | 102.17 |
| TDBM' 2020 | USD | 9.375% | 103.60 |

Зах зээлийн хүү

| Хүү | Хаалт | Өөрчлөлт |
|--------------|-------|----------|
| Libor 1M | 2.430 | -0.01 ▼ |
| Libor 3M | 2.520 | 0.00 |
| Libor 6M | 2.550 | 0.00 |
| Libor 1YR | 2.620 | -0.01 ▼ |
| US 2YR Bond | 2.164 | -0.05 ▼ |
| US 3YR Bond | 2.103 | -0.05 ▼ |
| US 5YR Bond | 2.121 | -0.06 ▼ |
| US 10YR Bond | 2.320 | -0.08 ▼ |

Валютын ханш /төг/

| Валют | 2019.05.24 | Өөрчлөлт |
|-------|------------|----------|
| USD | 2,647.27 | 0.04% ▲ |
| CNY | 383.38 | 0.14% ▲ |
| EUR | 2,961.90 | 0.14% ▲ |
| RUB | 40.97 | 0.02% ▲ |
| KRW | 2.23 | 0.90% ▲ |
| JPY | 24.17 | 0.21% ▲ |
| CAD | 1,967.28 | 0.09% ▲ |

Түүхий эдийн үнэ

| Түүхий эд | Хэмжих нэгж | Хаалт | Өөрчлөлт |
|------------------|-------------|----------|----------|
| Алт /spot/ | USD/t oz. | 1,284.93 | 0.58% ▲ |
| Мөнгө /spot/ | USD/t oz. | 14.57 | 1.15% ▲ |
| Зэс | USD/lb. | 269.95 | -1.42% ▼ |
| Нүүрс | USD/MT | 82.10 | -1.20% ▼ |
| WTI газрын тос | USD/bbl. | 58.63 | -6.58% ▼ |
| Brent газрын тос | USD/bbl. | 68.69 | -4.87% ▼ |
| Байгалийн хий | USD/MMBtu | 2.60 | -1.14% ▼ |

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | Хугацаа | Хэмжээ |
|----------------------------------|----------|--------|
| Инфляцийн түвшин | 2019. IV | 7.00% |
| Бодлогын хүү | 2019. IV | 11.00% |
| Банк хоорондын зах зээлийн хүү | 2019. IV | 11.02% |
| Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/ | 2019. IV | 11.83% |
| Хадгаламжийн дундаж хүү /валют/ | 2019. IV | 4.95% |
| Зээлийн дундаж хүү /төгрөг/ | 2019. IV | 17.11% |
| Зээлийн дундаж хүү /валют/ | 2019. IV | 10.57% |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 37 компанийн 478.0 сая төгрөгийн 5,262,587 ширхэг хувьцаа арилжигдав.


“Хай би ойл” /HBO/ компанийн хувьцаа 11.85%-аар буюу хамгийн ихээр өсөж 47.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Өндөрхаан” /ONH/ компанийн хувьцаа 14.88%-аар буурч 3,660.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 156 ширхэг үнэт цаас 16.4 сая төгрөгөөр арилжаалагджээ.


5-р сарын 24-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,371.0 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,952.98 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.45%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

| Хураангуй | Үнийн дүн /сая төг/ |
|-----------------------|---------------------|
| Арилжигдсан үнийн дүн | 494.5 |
| Зах зээлийн үнэлгээ | 2,370,975.5 |

Зах зээлийн индекс

| Индекс | Хаалт | Өөрчлөлт |
|---------------|-----------|----------|
| MSE Top 20 | 19,952.98 | -1.45% ▼ |
| MSE I индекс | 9,283.03 | -0.88% ▼ |
| MSE II индекс | 7,795.62 | -0.25% ▼ |

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

| Компани | Ширхэг | Үнийн дүн /төг/ |
|----------------|-----------|-----------------|
| Монос хүнс | 4,395,321 | 309,569,898 |
| Монгол шуудан | 53,500 | 28,358,180 |
| ЛэндМН ББСБ | 350,336 | 22,036,207 |
| АПУ | 31,223 | 17,971,992 |
| Монгол базальт | 65,810 | 17,326,856 |

Өсөлттэй хувьцаа

| Компани | Хаалт /төг/ | Өөрчлөлт |
|----------------------|-------------|----------|
| Хай би ойл | 47.00 | 11.85% ▲ |
| Монгол базальт | 269.00 | 9.21% ▲ |
| Фронттиер лэнд групп | 180.00 | 2.86% ▲ |
| Айтүүлс | 89.80 | 2.05% ▲ |
| Таван толгой | 6,400.00 | 1.59% ▲ |

Бууралттай хувьцаа

| Компани | Хаалт /төг/ | Өөрчлөлт |
|---------------------------------|-------------|-----------|
| Өндөрхаан | 3,660.00 | -14.88% ▼ |
| Баянтээг | 20,660.00 | -13.92% ▼ |
| Нако түлш | 80.00 | -11.11% ▼ |
| Хөх ган | 80.00 | -9.09% ▼ |
| Эрдэнэ ресурс девелопмент корп. | 500.25 | -6.50% ▼ |

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

| Компани | Арилжааны үнийн дүн /төг/ |
|------------------|---------------------------|
| Голомт капитал | 15,724,026,392 |
| Бумбат Алтай | 407,162,450 |
| Ард Секюритиз | 395,005,853 |
| Би Ди Сек | 285,031,298 |
| Ти Ди Би Капитал | 179,594,200 |

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

| Компани | Хаалт /төг/ | ЗЗҮ /сая.төг/ |
|--------------|-------------|---------------|
| АПУ | 575.93 | 612,894 |
| Таван толгой | 6,400.00 | 337,057 |
| МИК | 13,990.00 | 289,723 |
| Говь | 285.87 | 223,011 |
| Сүү | 199.40 | 68,594 |

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

| № | Үнэт цаасны нэр | Арилжигдсан ширхэг | Үнийн дүн /төг/ | Доод /төг/ | Дээд /төг/ | 7 хоног | Хүү |
|---|------------------------------|--------------------|-----------------|------------|------------|---------|---------|
| 1 | ZGEB-BD-20/06/20-A0260-15.14 | 156 | 16,440,840 | 105,390 | 105,390 | 156 | 15.140% |

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

| № | Симбол | Компанийн нэр | 2018 оны цэвэр ашиг /сая төг/ | Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/ | Ногдол ашиг төлөлтийн харьцаа | Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/ | Шийдвэр огноо | Бүртгэлийн өдөр | Хуваарилах өдөр |
|----|--------|---|-------------------------------|---------------------------------------|-------------------------------|----------------------------------|---------------|-----------------|----------------------|
| 1 | HRM | Гермес центр ХК | 783.4 | 298.5 | 38.1% | 3.8 | 2019.01.25 | 2019.02.18 | 2019.03.18-нд олгов |
| 2 | LEND | ЛэндМН ББСБ | 2,560.3 | 800.0 | 31.2% | 1.0 | 2019.01.30 | 2019.02.22 | 2019.03.28-нд олгов |
| 3 | MBW | Монгол Базальт ХК | 217.2 | 56.4 | 26.0% | 1.0 | 2019.02.01 | 2019.03.25 | 2019.10.01-с |
| 4 | BTG | Баянтээг ХК | 1,771.4 | 1,000.0 | 56.5% | 3,958.7 | 2019.02.11 | 2019.03.04 | 2019.06.01-с |
| 5 | SUL | Жуулчин дюти фрий ХК | 1,384.5 | 653.6 | 47.2% | 10,000.0 | 2019.02.12 | 2019.04.10 | 2019.05.31-с |
| 6 | GOV | Говь ХК | 17,764.2 | 5,304.8 | 29.9% | 6.8 | 2019.02.13 | 2019.03.28 | 2019.04.25-с |
| 7 | ADU | Хөвсгөл алтан дуулга ХК | 399.2 | 1,888.1 | 473.0% | 120.0 | 2019.02.13 | 2019.04.01 | 2019.05.01-с |
| 8 | TCK | Талх чихэр ХК | 1,975.9 | 204.7 | 10.4% | 200.0 | 2019.02.14 | 2019.04.03 | 2019.07.01-с |
| 9 | MMX | Мах импекс ХК | 778.6 | 456.1 | 58.6% | 120.0 | 2019.02.14 | 2019.04.03 | 2019.10.01-с |
| 10 | BUK | УБ-БҮК ХК | 566.4 | 131.5 | 23.2% | 1.0 | 2019.02.14 | 2019.04.05 | 2019.05.01-с |
| 11 | ТАН | Тахь-ко ХК | 799.1 | 128.5 | 16.1% | 108.0 | 2019.02.15 | 2019.04.05 | 2019.04.24-нд олгов |
| 12 | BNG | Баянгол зочид буудал ХК | 3,433.1 | 150.2 | 4.4% | 355.0 | 2019.02.16 | 2019.04.05 | 2019.09.01-с |
| 13 | MNP | Монгол шуудан ХК | 1,560.3 | 468.1 | 30.0% | 4.7 | 2019.02.18 | 2019.04.05 | 2019.05.01-с |
| 14 | HRD | Хүрд ХК | 751.1 | 74.4 | 9.9% | 550.0 | 2019.02.18 | 2019.03.04 | 2019.06.01-ний дотор |
| 15 | MNDL | Мандал даатгал ХК | 3,868.3 | 624.3 | 16.1% | 100.0 | 2019.02.18 | 2019.04.10 | 2019.05.01-с |
| 16 | GTL | Гутал ХК | 2,225.8 | 1,257.7 | 56.5% | 777.0 | 2019.02.18 | 2019.03.13 | 2019.05.06-с |
| 17 | TEX | Техник импорт ХК | 2,702.0 | 723.4 | 26.8% | 500.0 | 2019.02.18 | 2019.03.11 | 2019.04.11-с |
| 18 | APU | АПУ ХК | 57,851.7 | 48,952.4 | 84.6% | 46.0 | 2019.02.19 | 2019.04.04 | 2019.05.20-нд олгов |
| 19 | AIC | Ард даатгал ХК | 1,263.4 | 631.8 | 50.0% | 25.3 | 2019.02.19 | 2019.03.15 | 2019.06.29-ний дотор |
| 20 | GHC | Ган хийц ХК | 20.3 | 12.1 | 59.7% | 50.0 | 2019.02.19 | 2019.03.22 | 2019.10.01-с |
| 21 | HUV | Хөвсгөл геологи ХК | 107.4 | 14.4 | 13.4% | 100.0 | 2019.02.19 | 2019.04.03 | 2019.04.29-с |
| 22 | HNS | Хөвсгөл хүнс ХК | 11.3 | 2.6 | 23.4% | 10.0 | 2019.02.19 | 2019.04.03 | 2019.05.15-с |
| 23 | TAL | Талын гал ХК | 255.9 | 34.7 | 13.6% | 50.0 | 2019.02.25 | 2019.03.26 | N/A |
| 24 | BRC | Барилга корпораци ХК | 1,311.0 | 40.1 | 3.1% | 985.0 | 2019.02.26 | 2019.03.18 | 2019.03.18 |
| 25 | UBH | Улаанбаатар хивс ХК | 235.6 | 48.6 | 20.6% | 120.0 | 2019.02.26 | 2019.03.18 | 2019.05.31-ний дотор |
| 26 | DSS | Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК | 11.5 | 11.4 | 99.2% | 1.1 | 2019.03.01 | 2019.03.21 | 2019.07.02-с |
| 27 | ADL | Адуунчулуун ХК | 547.1 | 409.7 | 74.9% | 130.0 | 2019.03.11 | 2019.04.03 | 2019.12.31-ний дотор |
| 28 | TEE | Тээвэр дархан ХК | 22.3 | 81.7 | 365.5% | 500.0 | 2019.04.17 | 2019.03.27 | 2019.12.31-ний дотор |
| 29 | ERS | Монгол алт ХК | 6.3 | 39.9 | 631.2% | 150.0 | 2019.04.17 | 2019.03.27 | 2019.12.31-ний дотор |
| 30 | TTL | Таван толгой ХК | 52,858.1 | 44,923.4 | 85.0% | 853.0 | 2019.04.26 | 2019.04.01 | 2019.05.03-ны дотор |
| 31 | EER | Ариг гал ХК | 449.3 | 109.4 | 24.3% | 32.5 | 2019.04.26 | 2019.03.27 | 2019.09.30-ны дотор |

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Инвексдор ББСБ” ХК-ийн үнэт цаасны захиалга хүлээн авах үйл ажиллагаатай холбогдуулан цан цохих ёслол боллоо

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн “Инвексдор ББСБ” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлсэнтэй холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагаа 5-р сарын 22-ны өдөр боллоо. Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга С.Даваасүрэн, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, “Инвексдор ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Анхболд, “Инвексдор ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Баясгалан, “Ти Ди Би капитал ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Батчимэг, “Инвексдор Капитал ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Уянгахишиг нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны 5,978 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

“Инвексдор ББСБ” ХК нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулсан 3-р самбарт бүртгэгдсэн бөгөөд энэхүү самбарт бүртгэгдсэн үнэт цаасны арилжаанд өмнө нь олон нийт түлхүү оролцдог байсан бол тус компани нь санал болгож буй нийт хувьцааныхаа 85 хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох замаар мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог хангаж буйгаараа онцлогтой юм.

“Инвексдор ББСБ” нь 2019 онд финтект суурилсан бичил зээлийн аппликэйшн, цахим хэтэвч, мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг холбосон шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нийлүүлэхээр төлөвлөж байгаа төдийгүй, цаашид Төв Ази, Зүүн Өмнөд Азийн улсуудад үйл ажиллагаагаа тэлэх зорилготой ажиллаж байгаа тухай үнэт цаасны танилцуулгандаа дурджээ.


Мөн банк бус санхүүгийн салбарын тэргүүлэгч компани болох “Инвексдор ББСБ” ХК нь Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдэн, нээлттэй хувьцаат компани болж буйтай холбогдуулан олон нийтэд зориулсан үнэт цаасны танилцуулга арга хэмжээ 5-р сарын 22-ны өдөр Шангри-Ла зочид буудалд амжилттай зохион байгуулагдлаа.

Тус арга хэмжээнд нийт 500 гаруй зочид, төлөөлөгчид, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид оролцож, компанийн цаашдын стратеги төлөвлөгөө, бизнесийн үйл ажиллагаа, нийтэд санал болгож буй үнэт цаасны талаар мэдээлэл авч, улмаар үнэт цаас гаргагч, аудит, үнэлгээ болон хуулийн зөвлөх, андеррайтераар ажилласан байгууллагуудаас сонирхсон асуултууддаа хариулт авлаа.

Энэхүү IPO нь Монголын хөрөнгийн биржийн түүхэн дэх хувийн хэвшлийн хамгийн том IPO болж буйгаараа онцлог бөгөөд тус компанийн андеррайтераар “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК, туслах андеррайтераар “Инвексдор Капитал ҮЦК” ХХК ажиллаж байна.

Үнэт цаасны худалдан авах захиалгыг 2019 оны 5-р сарын 22-29-ний өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд, 5-р сарын 30-ны өдөр 10:00-15:00 цаг хүртэл Монголын хөрөнгийн биржийн бүх гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан хүлээн авах юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, iKon.mn



“АПУ” ХК 2018 оны ногдол ашгийг, “Материал импекс” ХК 2016 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийнхээ дансанд байршууллаа

“АПУ” ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 41 төгрөг 40 мөнгө (татварын дараах) тараасныг 2019 оны 5-р сарын 20-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

Мөн “Материал импекс” ХК-ийн 2016 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 16.20 төгрөг (татварын дараах) тараасныг 2019 оны 5-р сарын 09-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв



“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн”-ээс ирүүлсэн мэдэгдэл

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн (TSX:ERD | MSE:ERDN) нь 2019 оны 2-р улирлын өрөмдлөгийн ажлын хөтөлбөрийн үр дүнг танилцуулсан хэвлэлийн мэдээг ирүүлсэн байна.

Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрөөр Мидфийлд бүсэд 112 метрийн интервалтай 5.9 г/т алт огтолсон нь одоогоор Баян Хөндийн өрөмдлөгийн хамгийн сайн үр дүнгүүдийн нэг болсон төдийгүй өмнө нь хайгуул хийгдээгүй бүсэд алтны өндөр агуулгыг нээн илрүүлсэн тухай мэдэгдэлд дурджээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны ээлжит VIII хуралдаан болов

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны ээлжит VIII хуралдаан 5-р сарын 23-ны өдөр болж нийт 19 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Үнэт цаасны салбарын зургаан асуудлыг хэлэлцэж, “Жимобайл вексель” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож үнэт цаасыг бүртгэв. Мөн “Санлавмэд” ХХК-д хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл олгож, “МОСТ Финтек” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэлээ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах 3 асуудлыг хэлэлцэж зөвшөөрөл олгов.

Хуралдаанаар “Байтерек” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгаж, “Лэндмн ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “Жи Эс Би капитал ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олголоо.

Түүнчлэн “Добино” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг, “Санлавмэд ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гаргав.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Экспортын 83.2%-ийг эрдсийн бүтээгдэхүүн эзэлж байна

Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт эхний 4 сарын гүйцэтгэлээр 4.28 орчим тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 15.4%-иар өссөн байна. Экспорт хувьд өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 18.2%-иар өсчээ.

Нийт экспортын 83.2%-ийг эрдэс бүтээгдэхүүн эзэлж байна. Тэр дундаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, жонш, молибденийн баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нийт эрдсийн экспортын 98.6%-ийг бүрдүүлжээ.

Нүүрсний экспортын тухайд оны эхний дөрвөн сард 11.4 сая тонн нүүрс экспортолж, 961 сая ам.долларын орлого олсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал биет хэмжээгээр 1.23 орчим сая тонноор өссөн байна. Нийт нүүрсний 97.7%-ийг БНХАУ руу нийлүүлжээ.

Зэсийн баяжмал 489.1 мянган тонн экспортлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 30.5 мянган тонноор нэмэгдэж, хилийн дундаж үнэ 1368.6 ам.доллараас 1434 ам.доллар болж өссөн байна.

Боловсруулаагүй нефтийн экспорт 2105.9 мянган баррель буюу өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 104.3 мянган баррелаар буурсан байна.

Төмрийн хүдэр 2842.1 мянган тонн экспортолж, 2018 оны мөн үеэс 806.4 мянган тонноор өсчээ.

Цайрын баяжмал 54.1 мянган тонн экспортолсон бөгөөд өнгөрсөн оны мөн үед 54.9 мянган тоннын гүйцэтгэлтэй байжээ.

Жонш 151.8 мянган тонн экспортолж, 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс 37.9 мянган тонноор өссөн байна. Жоншны нийт экспортын 64.4%-ийг Хятад, 34.9%-ийг Орос, үлдсэн нь Өмнөд Солонгос руу гарсан байна.

Молибденийн баяжмалын экспорт 1864.1 тоннд хүрсэн өмнөх оны мөн үеийнхээс буурсан үзүүлэлттэй байна. Уг баяжмалын 81.4%-ийг Хятад руу гаргажээ.

Алтны хувьд 4.66 тонн алт экспортлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.23 тонноор их байна.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

Хонь, ямааны махны экспорт өмнөх оноос 2.7 дахин өсөөд байна

2019 оны эхний дөрвөн сард Монгол Улс 2.5 сая ам.долларын үнийн дүн бүхий хонь, ямааны махыг Вьетнам, Иран улсад экспортолсон байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.7 дахин өссөн дүн юм.

Мөн тайлант хугацаанд нийт 17.3 сая ам.долларын мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс өсөн хувиар өсжээ. Үүнээс адууны махыг БНХАУ, Казахстан, ОХУ, Японд гаргажээ. Сүүлийн жилүүдэд махны экспорт тогтвортой өсөж ирсэн төдийгүй 2017 оноос хойш огцом өссөн байна.

Хэдий тийм боловч дотоодын махны нийлүүлэлт хомсдсоноос үүдэж Засгийн газар хонь, ямааны махны экспортод квот тогтоохоор шийдвэрлээд байна. Тухайлбал, экспортлогчдод гадагш гаргаж буй махныхаа 10 хувьтай тэнцэх хэмжээний махыг нөөцлөх, эсвэл дотоодын зах зээлд худалдах шаардлага тавих юм. Нөгөө талаас энэ онд махны нөөцийн хэмжээ хангалтгүй байсан гэж дүгнэж болохоор байна. Тиймээс энэ оны 4,000 тонн нөөцийн махны хэмжээг ирэх онд дөрөв дахин өсгөж, багадаа 15 мянган тоннд хүргэнэ гэж салбарын сайд нь мэдэгдлээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Дэлхийн банк: Монгол Улсад 10 тэрбум ам.долларын үнэ цэн бүхий газрын ховор элемент бий

Монголд газрын ховор элементийн хайгуулын ажлыг Германы талтай хамтран идэвхжүүлэх сонирхолтой байгаагаа Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ. Энэ долоо хоногт Монгол, Германы Засгийн газар хоорондын ажлын хэсгийн хуралдаан болсон бөгөөд энэхүү хуралдаанд Уул уурхай, Хүнд үйлдвэрийн Сайд Д.Сумъяабазар оролцох үедээ энэ талаар дурджээ.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан газрын ховор элементийн геологийн нарийвчилсан судалгаа хийгдээгүй байгаа ч Халзан бүрэгтэй, Лугийн гол, Мушгай худаг, Цагаан чулуут, Хотгор зэрэг газрын ховор элементийн нөөц, баялаг агууламж бүхий ордууд, томоохон 71 илрэл, 300 гаруй эрдэсжсэн цэг байгааг тогтоосон талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яамнаас мэдээллээ.

Монгол Улсад 10 тэрбум ам.долларын үнэ цэнэ бүхий газрын ховор элемент бий гэсэн тооцоог Дэлхийн банк гаргасан талаар мөн танилцуулсан юм. Энэ онд Ховд аймгийн Мянгад сумын нутагт байрлах Халзан бүрэгтэй ордын үйл ажиллагааг эхлүүлэхээр ТЭЗҮ батлуулсан талаар Ашигт малтмал, Газрын тосны газар мэдээлж байсан юм.

Олон улсыг харвал цахилгаан хэрэгсэл, технологийн шинэ бүтээгдэхүүнээс эхлээд цэргийн зэвсгийн үйлдвэрлэлд ч өргөнөөр ашиглагддаг газрын ховор элементийн олборлолтын 80 хувийг БНХАУ нийлүүлдэг. АНУ тус улсаас ихээхэн хамаардаг. АНУ, БНХАУ-ын "Худалдааны дайн" дахин хурцадсан энэ үед БНХАУ газрын ховор элементийг хэрэгсэл болгон ашиглаж магадгүй гэж шинжээчид харж байна. Зургаадугаар сарын нэгнээс эхлэн БНХАУ АНУ-ын импортлолж байгаа бүтээгдэхүүний тарифыг 25 хувь болгон нэмэгдүүлсний дунд газрын ховор элементийн хүдэр багтаж байгаа юм.

Энэ долоо хоногт БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жинпин Жяньси муж дахь газрын ховор элементийн үйлдвэрээр зочилсны дараа "MVIS Global Rare Earth/ Strategic Minerals Index" нэг өдрийн дотор 6.4 хувиар өссөн нь 2011 оны аравдугаар сараас хойш байгаагүй өсөлт болжээ. Энэхүү индексэд газрын ховор элемент олборлогч БНХАУ, Австрали, Канад зэрэг 10 улсын 20 компани багтдаг юм байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

I улиралд БНХАУ-ын гангийн гарц өсөж, түүхэнд байгаагүй дээд түвшинд хүрчээ

БНХАУ-ын гангийн гарц I улиралд өсөж "Оны I улирал" гэсэн үзүүлэлтээр авч үзвэл тус улсын түүхэнд өмнө нь байгаагүй дээд түвшинд хүрлээ.

Улирлын хугацаанд 231 сая тонн ган үйлдвэрлэсэн байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 10 хувиар өссөн үзүүлэлт юм. БНХАУ-ын Засгийн газар эдийн засгийг дэмжих хөтөлбөрөө идэвхжүүлж дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлж байгаа нь гангийн хэрэглээ өсөх шалтгаан болсон байна. Энэ онд БНХАУ-ын гангийн хэрэглээ нэг хувиар өснө гэсэн таамгийг Дэлхийн гангийн холбоо дэвшүүлээд байгаа юм. Харин ирэх 2020 онд хэрэглээ эргээд буурна гэж харж байгаа юм байна. Гангийн үйлдвэрлэлийн хувьд энэ онд 1.8 хувиар өснө гэж "Shanghai Steelhome Information Technology" урьдчилан тооцоолоод байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Монгол улсын эдийн засгийн 2019 оны 4-р сарын байдал

Дотоодын нийт бүтээгдэхүүн

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2019 оны эхний улиралд урьдчилсан гүйцэтгэлээр 3.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 279.9 (8.6%) тэрбум төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 127.7 (8.0%) тэрбум төгрөг (бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэмэгдэл өртөг 52.2 (13.9%) тэрбум төгрөг), аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 124.9 (11.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

ДНБ, оны үнээр 2019 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 7.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.2(17.0%) их наяд төгрөгөөр өслөө.

Мөнгө, зээл

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 4-р сарын эцэст 19.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 188.7 (1.0%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.6 (22.5%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 4-р сарын эцэст 933.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 35.2 (3.9%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 4.6 (0.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 4-р сарын эцэст 17.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 182.8 (1.0%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.2 (21.9%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 4-р сарын эцэст 980.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 66.3 (7.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1.6 (0.2%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.6 хувийг эзэлж, өмнөх сараас 0.4 пунктээр өсөж, өмнөх оны мөн үеэс 1.2 пунктээр буурсан байна.

Монголбанкны төгрөгийн америк доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2019 оны 4-р сард 2,634.93 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.0 хувиар, өмнөх сараас 0.1 хувиар тус тус суларсан байна.

Монголбанкны төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2019 оны 4-р сард 392.28 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар суларч, өмнөх сараас 0.01 хувиар чангарсан байна.

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 3.1 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2.8 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 286.5 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 4 дүгээр сард 968.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 259.5 (36.6%) тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 876.4 тэрбум төгрөгт хүрч, 59.6 (7.3%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Татварын нийт орлого 2019 оны эхний 4 сард 2.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 634.9 (28.6%) тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 228.9 (39.5%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 165.9 (37.5%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 66.9 (31.8%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 65.8 (28.5%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 43.0 (24.3%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 56.2 (10.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 81.5 хувийг татварын орлого, 7.8 хувийг татварын бус орлого, 10.1 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 0.6 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 277.4 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 70.8 сая америк доллараар буурчээ.

Урсгал данс 297.6 сая америк долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 553.2 сая америк доллар, анхдагч орлогын данс 196.2 сая америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн данс 2019 оны эхний улиралд 20.2 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 8.5 (71.9%) сая америк доллараар өссөн байна.

Харин санхүүгийн дансны тэнцэл 318.5 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 79.4 сая америк доллараар өсжээ.

Төлбөрийн тэнцэл 2019 оны эхний улиралд 219.0 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 261.2 сая америк доллараар өссөн байна.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх сараас 1.0 хувь, өмнөх оны эцсээс 2.8 хувь, өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 8.3 хувь (мах, махан бүтээгдхүүний дэд бүлгийн үнэ 20.4 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 6.6 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.6 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 5.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 8.9 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 9.6 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 4 дүгээр сард өмнөх оны эцсээс 2.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.4 хувь (мах, махан бүтээгдэхүүн 22.9 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 2.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 1.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.